

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБАНЫ
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ АШИГЛАЛТЫГ
ХӨГЖИНГҮЙ ОРНЫ ТҮВШИНД ХҮРГЭХ БОЛОМЖ

Улам бүр даяаршин буй дэлхий ертөнцөд шинжлэх ухаан, холбоо мэдээллийн технологи асар хурдацтайгаар хөгжиж, үүний үр дүнд улс орнууд, бизнесийн болон төрийн байгууллага, иргэн бүхэн хүссэн мэдээ мэдээллээ хүлээн авах, солилцох, түгээн сурталчлах өргөн боломж, бололцоо тэгш нээгдээд байна.

Шинжлэх ухаан, холбоо, мэдээллийн технологийн ололт, дэвшил дээр суурилсан мэдээллийн системийг оновчтой, зөв зохион байгуулсан, түүнд суурилсан удирдлагын менежментийг нэвтрүүлж, оновчтой шийдвэр гаргаж чадсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь цаг хугацааны шалгуурыг даван туулж чадах, өрсөлдөх чадвар сайтай, илүү бүтээлч, ажил хэрэгч, ажил, үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа нь үр дүн сайтай байдаг нь нэгэнт тодорхой болоод байна.

Монгол улс шиг өргөн уудам нутагтай, хүн ам сийрэг суурьшилттай, цөөн хүн амтайгаа харьцуулахад олон засаг захиргааны нэгжтэй улсад мэдээллийн технологи дээр суурилсан байгууллагын мэдээллийн системийг оновчтой зохион байгуулах нь нүсэр бүтэцтэй төрийн байгууллагуудын хувьд мэдээллийн урсгалаа удирдах, хянах, боловсруулах, нэгтгэх, түгээх, солилцох, төрийн зүгээс ард иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх өнөөгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлагын талаас нь харах юм бол асар их ач холбогдол бүхий тулгамдсан асуудлын нэг юм.

Монгол улс дэлхийн хөгжилтэй орнуудтай харицуулахад зам, гүүр, тээвэр, барилга, эрчим хүч зэрэг дэд бүтцийн хөгжлийн хувьд хэдэн арван жилээр хоцрогдсон. Өнөөдрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдлаас харахад өндөр хөгжилтэй орны түвшинд хүрэхэд бас л хэдэн арван жилийн хөгжлийн хугацаа хэрэгтэй болох төлөвтэй байна.

Харин мэдээллийн технологийн хувьд хөгжилтэй орны түвшинд хүрэхэд тийм их урт хугацаа орохгүй юм. Дэлхий нийтийг хамарсан холбоо, мэдээллийн сүлжээний дэд бүтэц, мэдээллийн технологийн шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хөгжлийн өнөөгийн түвшин бидэнд ийм бололцоог олгож байна. Харин бид энэ бололцоог зөв олж харж, цаг хугацаа алдахгүйгээр байгууллага, иргэн бүр хөдөлмөр, зохион байгуулалт, удирдлагын зөв менежмент, хөрөнгө санхүүжилтийн зөв зарцуулалт, уян хатан бодлого явуулж дэлхийн мэдээллийн технологийн хөгжлийн түвшинд зэрэгцэн очих шаардлагатай байгаа юм.

Монголын татварын албаны мэдээллийн системийн ойрын ирээдүйн чиг хандлага, боломж бололцоог товч тодорхойлох нь энэхүү илтгэлийн зорилго боловч татварын системийн өнгөрсөн 16 жилд туулж ирсэн хөгжлийн түүх, хандлага, өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, дэвшилттэй болон дутагдалтай талуудыг дүгнэн тодорхойлох нь ирээдүйн мэдээллийн технологийн хөгжлийн сууриа зөв тавихад зайлшгүй чухал юм.

Илтгэл нь доорх 3 бүлгээс тогтоно.

1. Байгууллагын мэдээллийн системийн ерөнхий ойлголт
2. Татварын албаны мэдээллийн системд хийх дүн шинжилгээ
3. Татварын албаны мэдээллийн системийг хөгжингүй орны түвшинд хүргэх гадаад болон дотоод нөхцөл, түүнийг цаг алдалгүй хэрэгжүүлэх боломж

1. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Аливаа бизнесийн болон төрийн байгууллагын дотоод бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг даган мэдээлэл солилцооны урсгалын бүтэц тодорхойлогддог. Энэ мэдээллийн урсгал бүтэц дээр суурилан мэдээллийн технологи, сүлжээний бүтэц, мэдээллийн баазын бүтэц загвар, програм хангамжийн шийдэл боловсруулагдана. Тухайн байгууллагын бүтэц, бизнес үйл ажиллагааны онцлогийг харуулсан мэдээллийн урсгалын загварчлал, мэдээллийн урсгалын загвар бүтэцийг даган хийгдсэн мэдээллийн сүлжээ, сүлжээ мэдээллийн технологи, мэдээллийн баазын загвар, түүнд суурилсан програм хангамжийн цогц нэгдлийг тухайн байгууллагын

удирдлагын мэдээллийн систем (AIS) гэж нэрлэдэг. Иймээс байгууллагын удирдлагын мэдээллийн систем нь доорхи үндсэн 3 гол хэсгээс бүрдэнэ гэж үзэж болно.

- Тухайн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, бизнес үйл ажиллагааны шаардлагын үүднээс үүсч байгаа мэдээллийн урсгалын бүтэц
- Мэдээллийн урсгалын бүтэц, түүний онцлогийг агуулсан мэдээллийн сүлжээ, мэдээллийн технологи, компьютер, тоног төхөөрөмж(үүнийг байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтэц гэж үзэж болно)
- Байгууллагын бизнес үйл ажиллагааны шаардлагыг хангасан мэдээллийн баазын зөв бүтэц, түүнд суурилсан уян хатан шийдэл бүхий програм хангамж

Байгууллагын мэдээллийн системийн үндсэн зорилго нь:

- Байгууллагын бизнес үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангах;
- Төлөвлөгдсөн бизнес үйл ажиллагааг үр ашигтай явуулахад байнгын хяналт тогтоох техник, технологийн нөхцөлийг хангах;
- Байгууллагын бүх шатны удирдлагыг байгууллагын бизнес үйл ажиллагааны урсгал мэдээллээр байнга, тасралтгүй, бодлогын шийдэл, оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай үнэн зөв мэдээллээр тогтмол, шуурхай хангах;

2. ТАТВАРЫН АЛБАНЫ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 Монголын татварын албаны мэдээллийн систем үүссэн нөхцөл байдал, хөгжлийн түүх

Монгол улсын татварын албаны эрхэм зорилт болох татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилэнд нь хяналт тавих, татвар төлөгчийг мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааны үндсэн чиг үүргээ даган хийгдсэн Монгол улсын татварын албаны бүтэц бүрэлдэхүүн, татварын албад, хэлтэс, тасаг, нэгж, тэдгээрийн хоорондын ажлын чиг үүргийн уялдаа, холбоо зэрэг үндсэн үйл ажиллагааны дагуу татварын албаны мэдээллийн урсгалын бүтэц тодорхойлогддог.

ТЕГ-ын Мэдээлэл боловсруулах хэлтэс нь анх 1993 онд байгуулагдан Хэлтсийн дарга, програм зохиогч-2, компьютерийн инженер-1, эдийн засагч-1 орон тооны бүрэлдэхүүнтэйгээр Монгол улсын татварын албаны мэдээллийн системийг үүсгэн байгуулах, татварын мэдээллийн урсгалыг автоматжуулах, удирдлагыг шуурхай мэдээллээр хангах үндсэн зорилготой ажиллаж эхэлсэн билээ.

Тухайн үе нь дэлхий нийтээр глобалчлагдан, дэлхийн хөгжингүй орнуудад мэдээллийн технологийн хөгжлийн үсрэнгүй үе ид хүчээ авч байсан боловч Монгол улсын хувьд улс төр, нийгэм, эдийн засгийн байдал тогтворжоогүй, санхүү төсвийн чадвах сул, дэд бүтэцийн хөгжил муутай холбоотой мэдээллийн системийг нэвтрүүлэх үйл ажиллагаа байгууллагуудад тэр тусмаа төрийн байгууллагад хүндрэлтэй байлаа.

Харин дэлхийн мэдээлэл, технологийн хөгжлийн глобалчлал, нээлттэй зах зээлтэй холбоотой мэдээлэл холбооны техник, тоног төхөөрөмж, электрон бараа, түүний дотор мэдээллийн технологийн үндсэн хэрэгсэл болох компьютер нь Монгол улсад орж ирэх, түүний үе шат бүрийг ашиглах эзэмших, хэрэглэх нь дэлхий нийтийн жишигээс хол хоцроогүй юм. Гагцхүү Монгол улсын дэд бүтэц, татварын албаны мэдээлэл технологийн мэргэжилтний хүрэлцээ, чадамж, хөрөнгө, санхүүжилт зэргээс шалтгаалж байгууллагын мэдээллийн систем бүрэн утгаараа ажиллаж чадахгүй байсаар байв.

1994-1998 онд татварын мэдээлэл DOS үйлдлийн системийн орчинд мэдээллийн баазын Dbase систем дээр суурилсан, компьютерийн дотоод сүлжээгээр холбогдоогүй, татвар төлөгчийн бүртгэл, татварын орлого, зэрэг мэдээллийг боловсруулдаг Clipper CA хэл дээр бичсэн цөөн хэдэн програмыг өөрсдийн мэргэжилтнүүдийн хүчээр боловсруулан албаны хэмжээнд нэвтрүүлж эхэлсэн юм. Улсын хэмжээнд татварын мэдээлэл нэгтгэх үйл ажиллагаа нь Монгол орны мэдээлэл, холбооны дэд бүтэцээс ихээхэн хамааралтай байлаа.

2.2 Монгол улсын мэдээллийн сүлжээний дэд бүтцийг даган өөрчлөгдөж буй татварын адбаны мэдээллийн сүлжээний одоогийн төлөв байдал

1990-ээд оны үед Татварын ерөнхий газар нь аймаг, нийслэл, дүүргийн татварын албадаас мэдээллийг сүлжээний Dial-Up(утсаар компьютер хооронд холбох) горимоор холбогдсон сүлжээгээр сардаа нэг удаа, зарим мэдээг улирал, жилдээ нэг удаа авч улсын хэмжээгээр нэгтгэл хийдэг байв. Ихэнх аймагуудаас тэр үед Монгол улсдаа хамгийн дэвшилттэй сүлжээний технологи байсан X-25 протокол дээр суурилсан орон нутгаас цаг уурын мэдээлэл дамжуулах зорилго бүхий мэдээлэл дамжуулах сүлжээг давхар ашиглаж мэдээлэл авдаг байлаа.

1998 оноос эхэлж ХБНГУ-ын зээл тусламжаар Монголын татварын албанд мэдээллийн баазын боловсронгуй систем болох дэлхийд эхний байранд орж байсан **ORACLE** системийг ашиглахыг санал болгосны дагуу төвлөрсөн мэдээллийн систем бүхий Клейнт-Сервэр технологийн горим бүхий техник, тоног тоөхөөрөмж, компьютер суурилуулах, мэргэжилтэн давтан бэлтгэх, сургах ажлууд хийгдсэн юм.

ORACLE системийг нэвтрүүлснээр татварын нэгжүүд дээр клиент/сервер технологи дээр суурилсан мэдээллийн бааз үүсгэх, программ хангамж боловсруулах ажлууд хийгдэж эхэлсэн бөгөөд энэ нь одоо ч үүргээ гүйцэтгэсээр байна.

Энэ системийг суурилуулснаар татварын албадууд дээр дотоод сүлжээнд суурилсан програм хангамжууд нэвтэрч олон хэрэглэгч нэг програм дээр зэрэг ажиллах

боломжтой болсон юм. *Эдгээр програмуудыг нэвтрүүлсний хамгийн давуу тал нь татварын албаны ажилтнууд тэр дундаа дунд шатны удирдлагуудад төвлөрсөн мэдээллийн системийн ач холбогдлыг ойлгож, тэдэнд анхны суурь ойлголтуудыг өгсөн явдал юм.*

Гэвч **ORACLE** системийг нэвтрүүлэхэд Монгол орны холбоо мэдээллийн сүлжээний дэд бүтэцээс шалтгаалж *мэдээлэлийг цаг тухай бїрд нь улсын хэмжээнд автоматаар нэгтгэх асуудал орхигдсон юм.* Иймээс татварын албадын мэдээллийг нэгтгэх ажиллагааг сард 2 удаа гараар, хагас автомат горимоор нэгтгэх болсон. Үүнээс үүдэн сар бүрийн **“5-ний бааз, 20-ний бааз”** гэсэн нэр томьёо татварын мэдээллийн баазыг нэгтгэх үйл ажиллагаанд бий болсон байна. Энэ нь тухайн үеийн мэдээллийг улирал, жилээр нэгтгэгдэг байсантай харицуулбал илүү дэвшилттэй байлаа. Гэвч тэр үеээс хойш 9 жил өнгөрч мэдээлэл технологийн хөгжлийн хурд дахин хэдэн үеээр урагшилж, Монгол улсын холбоо мэдээллийн сүлжээний дэд бүтэц сайжирсан байгаа зэрэг нь энэ байдлыг яаралтай өөрчлөх шаардлагатай болсон байгаа юм.

Татварын мэдээллийн системийн хамгийн чухал хэсэг болох мэдээллийн урсгалыг хянах їйл ажиллагаанд Татварын албаны мэдээллийн бодит цаг їеийн нэгтгэл байхгїйгээс сєрєг їр дагаварууд нилээд хуримтлагдан бий болсон байгаа юм.

Мэдээллийн системийн урсгалыг хянах хоёр гол субъект байдаг. Энэ нь **Нэгдүгээрт** мэдээлэл үүсгэгч өөрөө мэдээлэлээ хянаж байх ёстой. Энэ нь Татварын албаны хувьд татвар төлөгч өөрөө юм. Татвар төлөгчийн өөрийнх нь мэдээлэл өөрт нь нууц биш. Тиймээс тэд өөрсдийнхээ мэдээлэлийг хянах үүрэгтэй ба эрхтэй. **Хоёрдугаарт** уг мэдээллийн системийг ашиглаж удирдлагын шийдвэр гаргадаг удирдлага мэдээллийг өдөр тутам хянах боломжтой байх ёстой. Энэ нь манай татварын албаны шат шатны удирдлага, удирдлагын баг юм. Энэ хоёр субъектээр мэдээллийн системийн мэдээлэлийн урсгалын хяналт тогтоогдож, удирдлагын шийдвэрт нөлөөлөхүйц үнэн зөв, шуурхай байх гол нөхцөл бүрддэг. Гэтэл бид өнөөдрийн байдлаар 15 хоногийн дараа мэдээллийн баазаа нэгтгэж байгаа нь удирдлагыг мэдээлэлээр хангах, оновчтой шийдвэр гаргах өнөөгийн шаардлагыг хангаж чадахгүй байна. Тиймээс бид

мэдээллийн хяналтын үндсэн нөхцөл болсон мэдээлэл үүсгэгдсэн цаг минут бүрдээ автоматаар нэгтгэгдэж байдаг бодит цаг үеийн мэдээллийн нэгтгэл хийх техник технологи, програм хангамжийн нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай байна.

Энэ нь бидний цаашид Татварын албаны мэдээллийн урсгалыг өнөөгийн нөхцөл, шаардлагатай уялдуулан шинэ түвшинд гаргаж хөгжүүлэх гол үндсэн нөхцлийн нэг болно.

2003 оноос эхлэн Монгол улсад үүрэн телефон болон интернэт үйлчилгээний хувийн компаниудын зах зээлийн шударга өрсөлдөөнтэй холбоотой шилэн кабелийн дэд бүтцийн сүлжээ үүсэж, эрчимтэй хөгжиж ирсэн нь өөрийн хиймэл дагуул байхгүй манай орны хувд мэдээллийн сүлжээний тэргүүний технологи нэвтрүүлэх таатай нөхцөл бүрэн эхэлсэн юм. Манай татварын алба 2007 оноос эхлэн нийслэл, дүүргүүдэд шилэн кабелийн холболт хийж эхэлсэн бөгөөд 2010 оны 3 дугаар сард орон нутгийн 21 аймаг, Налайх, Багануур дүүргийг онлайн холбож дуусгалаа. Цаашид албадын онлайн холболтыг байнгын ажиллагаатай байлгах шаардлагатай байгаа юм. Энд манай улсын орон нутгийн эрчим хүч, сүлжээний дэд бүтэц ихээхэн хамааралтай байдгийг анхаарах хэрэгтэй.

Шилэн кабель нь мэдээлэл технологийн салбарын үсрэнгүй хөгжил, ололт амжилтыг шинжлэх ухааны салбараас хүний нийгмийн хэрэгцээнд авчирч энгийн хэрэглээ болгоход онцгой гайхамшигтай үүрэг гүйцэтгэсэн хүн төрлөхтөний өнөөгийн мэдэх хурдны дээд хязгаараар мэдээлэл дажуулах боломжтой технологи юм.

Шилэн кабелиар холбогдсон татварын албадад интернэт ашиглах, түүн дээр суурилсан цахим тайлангийн систем нэвтрүүлэх төдийгөөр бид шилэн кабелийн боломжийг ашиглаж байгаа нь учир дутагдалтай юм. Бид албадын онлайн холболтон дээрээ суурилан мэдээллийн баазын бодит цаг үеийн нэгтгэл хийх технологийг яаралтай нэвтрүүлэх шаардлагатай байгаа юм. Мэдээллийн баазын бодит цаг үеийн нэгтгэл нь татварын албаны цаашдын бизнес үйл ажиллагаанд олон давуу байдлуудыг бий болгоно.

Мэдээллийн баазыг бодит цаг үед нэгтгэснээр

- ✓ *Татвар төлөгчдөд өөрсдийн мэдээллийг интернэт ашиглан хэдийд ч шалгах, хянах нөхцөлийг бийрүүлж чадна.*
- ✓ *Татварын удирдлагыг бодит цаг үеийн мэдээллээр шуурхай хангах, мэдээллийн урсгалд хяналт тавих нөхцөлийг бийрүүлж чадна.*
- ✓ *Хөндөлөнгийн байгууллагуудтай бодит цаг үеийн мэдээлэл солилцох нөхцөл бийрдэнэ.*

Мэдээллийн баазад бодит цаг үеийн нэгтгэл хийснээр бид цаашид татварын албаны мэдээллийн урсгалын чанарыг сайжруулахын зэрэгцээ татвар төлөгчийн бүртгэл, татварын бүртгэл, татвар хураалтын түвшин, татварын өр барагдуулалтын түвшин, тайлан хүлээн авалтын түвшин, татварын хяналт шалгалтын ажлын өдөр тутмын мэдээллийн урсгалыг татварын удирдлагаас хянах зэрэг үйл ажилагаанд эрс өөрчлөлт гарах болно.

Энэ нь удирдлагын бүх түвшинд мэдээлэл ашиглан шийдвэр гаргах технологийн шинэ горимд шилжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

Мөн мэдээллийг бодит цаг үед нэгтгэснээр татвар төлөгчийн татварын өр төлөх хугацаа, тайлан өгөх хугацааг e-майл, гар утсаар мессэж дамжуулж мэдэгдэх, цахим тайлангийн формуудыг шууд татвар төлөгч рүү дамжуулж хугацаанд нь бөглөж өгөхийг шаардах зэрэг татвар хураалтын зардлыг багасгах, үр ашгийг дээшлүүлэх олон ажлыг үр дүнтэй хийх технологийн нөхцөлийг бүрдүүлэх юм.

2.3 Татварын хэрэглээний програм хангамж боловсруулалт

Өнөөгийн байдал

Өнөөдрийн байдлаар татварын албанд өөрсдийн мэрэгжилтнүүдийн боловсруулсан ORACLE мэдээллийн бааз удирдлагын системд татварын мэдээллийн

бааз үүсгэх, боловсруулах зорилго бүхий ORACLE developer програмын хэл дээр бичсэн татварын албадад ашиглаж буй татварийн хэрээлээний 24 төрлийн програм, ТЕГ болон нийслэлийн татварын газар дээр нэгдсэн баазаас мэдээлэл харах зориулалт бүхий 9 төрлийн програм, интернэтээр татвар төлөгчөөс цахим тайлан хүлээн авах 5 програм, татвар төлөгч НӨАТ-ын падаан шивэх(Vat_Entry) нэг программ нийт 36 нэр төрлийн програм ажиллаж байна.

Давуу талууд

- Дээрх програмуудыг ашиглан татварын албаны өнөөгийн мэдээллэл боловсруулалтын үйл ажиллагаа зохицуулагдаж, эдгээр програмуудаар үүссэн татварын төвлөрсөн мэдээллийн баазаас татварын бүх албад шат шатандаа татварын албаны төрөл бүрийн хэрэгцээ шаардлагатай мэдээлэлийг гарган авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Эдгээр програмуудыг боловсруулах, нэвтрүүлэх, зүгшрүүлэх, өөрчлөх сайжруулах олон жилийн хөдөлмөрийн үр дүнд татварын албаны програм зохиогчид асар их ажил мэрэгжлийн дадлага туршлагатай болсон асар их давуу байдал бий болгож байна.
- Эдгээр програмууд дээр ажиллаж, төрөл бүрийн татварын мэдээлэл оруулж, боловсруулалт судалгаа хийж сурсан манай нийт татварын системийн байцаагчид маань төвлөрсөн мэдээллийн бааз, онлайн горимд ажиллах програм хангамжийн ач холбогдлыг ойлгож, эдгээр програмуудыг цаашид өөрчлөх, сайжруулах, боловсронгуй болгох талаар санал, шүүмжлэл өрнүүлэх хэмжээнд хүрсэн нь онцлог давуу талуудын нэг юм.
- Татварын албадтай онлайн холбогдсон нь програм зохиогчид заавал татварын албадын байцаагчдийн компьютер бүр дээр очиж програмын нэмэлт, өөрчлөлтийг хийж цаг хугацаа алдахгүйгээр төвөөс удирдан зохицуулах боломжтой болсон

Дугагдалтай талууд

- ☒ Анх эдгээр програмуудыг боловсруулж байх үед програм зохиогчдын маань ажлын дадлага туршлага, татварын талаар мэдлэг боловсрол бага нөгөө талаас програмын бодлогын даалгавар буюу татварын бизнесийн үйл ажиллагааг тодохойлж загварчилдаг татварын мэрэгжилтнүүд татварын ажлын урсгалаа гүйцэд харж чадаагүй, мэдээллийн баазын бүтэц, зохион байгуулалт, логик холбоосын талаар төсөөлөл байхгүй зэргээс шалтгаалж дутуу орхигдсон, гүйцэд хийгдээгүй, програмын зохиомж муу, давхцал ихтэй функц, процедурууд олон байгаа зэрэг дугагдлууд байгаа юм.
- ☒ Програм нь мэдээллийн баазын бүтэц дизайн зөв, бизнес үйл ажиллагаа бүрэн гүйцэд тодорхойлогдохоос ихээхэн шалтгаалдаг. Татварын албаны мэдээллийн баазын бүтэц буруу, вэб хандалттай цахим тайланг өмнөх тайлан хүлээн авах системтэй зэрэгцүүлэн нэвтрүүлсэнтэй холбоотой нэг програмыг програм зохиогч 3 удаа бичих шаардлага үүссэн нь програм зохиогчийн ажлын ачааллыг маш ихээр нэмэгдүүлж байна.
- ☒ Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологийн хөгжлийг даган татварын албаны болон татвар төлөгчийн татварын програм ашиглах хэрэгцээ хэдэн арав дахин нэмэгдсэн ч татварын хэргэлээний програм зохиогчийн тоо нэмэгдээгүй нь татварын хэргэлээний програм хэрэгцээ шаардлагыг гүйцэж чадахгүй байна.

Цаашид тавих зорилгууд

- ☞ ORACLE мэдээллийн бааз дээр үүссэн татварын мэдээллүүд нь татварын албаны түүхэн үйл ажиллагааны үнэ цэнэтэй цахим тул дараагийн шатанд програм хангамж болон програмын хэлийг өөрчилсөн ч мэдээллийн баазад нэгэнт хуримтлагдсан мэдээллийг хэвээр хадгалж улам боловсронгуй болгон өөрчлөх, шилжүүлэх, хувиргах замаар төгөлдөршүүлэх хэрэгтэй юм. Өмнө хуримтлагдсан мэдээлэл дээр туршилт хийх замаар програм боловсруулах нь шинээр бичихээс илүү хурдан, үр дүнтэй, цаг хугацаа хэмнэсэн ажил байдаг.

- ☞ Татварын албаны хэрэглээний програмууд нь үнэ цэнэтэй, татварын албанд оруулж байгаа оюуны хөрөнгө оруулалт мөн тул тодорхой шалгуураар буюу хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ тогтоолгон байгууллагын биет бус хөрөнгөөр бүртгэж авах шаардлагатай юм.
- ☞ Татварын албад хоорондын онлайн холболтонд суурилсан мэдээллийн бааз нэгтгэлийн автомат горимыг яаралтай ажилд оруулж, түүнтэй уялдан гарах програмын өөрчлөлтүүдийг хийж дуусгах хэрэгтэй.
- ☞ Интернет хэрэглээ Монгол улсад нийтийн хэрэглээ болон хөгжиж байгаатай холбоотой одоогийн татварын хэрэглээний програмуудыг вэб хандалттай програм болгон өөрчлөх нь татварын албаны мэдээллийн технологийн хөгжлийн ойрын ирээдүйн хөгжлийн ҮНДЭС СУУРЬ болох юм. Энэ нь маш их ач холбогдол, үр өгөөжтэй ажил боловч одоогийн татварын албаны мэргэжилтэн, техник тоног төхөөрөмжийн хангамж, төсөв санхүүгийн хүрээнд бол шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудал юм.
- ☞ Вэб хандалттай програмийг татварын албанд нэвтрүүлэхэд мэргэжилтүүдийг давтан сургах, ирээдүйн татварын албаны мэдээллийн системийн мэргэжилтнүүдийн тасралтгүй уламжлагдан ажиллах боломжийг бодолцон шинээр сайн програм зохиогчдыг сонгон шалгаруулж авах, дадлагатай мэргэжилтнүүдээрээ дагалдан сургах ажлыг одооноос эхлэн зохион байгуулж эхлэх ёстой.
- ☞ Мэрэгжлийн хэлтэс, газруудаас програм боловсруулахад шаардлагатай мэдээллийн урсгал загвар, дизайн, програмын бодлогын даалгавар боловсруулах үйл ажиллагаанд залуу, авьяаслаг мэргэжилтнүүдийг сонгон сургаж, дадлагажуулах, мэрэгшүүлэх шаардлагатай байна.
- ☞ Бусад хэлтэс, газруудтай ажлын уялдаа холбоогоо сайжруулж системийн хэмжээнд багаар ажиллах, өргөн хүрээнд байцаагчдийг програм хөгжүүлэх

явцад татан оролцуулах, хамтран ажиллах менежментийн уян хатан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

☞ Дэлхийн банкны төслийн хүрээний санхүүжилтийг татварын албанд вэб хандалттай програм хангамж худалдан авах, хөгжүүлэх, нэвтрүүлэх бодлогод чиглүүлэх нь Татварын албаны хэрэглээний програмыг хөгжингүй орны жижигт хүргэх одоогийн хойшлуулшгүй боломжийн нэг юм.

2.4 Мэдээллийн техник, тоног төхөөрөмж, компьютер хангамж

Өнөөгийн байдал

Өнөөдөөгийн мэдээлэл, технологийн эрэн үед ажлын байрыг компьютергүйгээр төсөөлөхөд хүнд болсон. 1993 онд тэр үед PC-386 гэж нэрлэж байсан компьютерийг сервер нэртэй толгой компьютер болгон PC-286 компьютерүүд дээр DOS үйлдлийн систем суулган Монголын татварын албаны програм боловсруулж, татварын мэдээлэл боловсруулах ажлын эхийг тавьж байсан нь саяхан мэт боловч аль хэдийн 16 жил өнгөрчээ. Татварын програм боловсруулах, компьютерд суулгах, татварын байцаагч нарт зааж сургах, компьютерийн эвдрэл, гэмтлийг засах, зарим үед татварын талаар хичээл заах хүртэл ажлуудыг програм зохиогч өөрөө хийх шаардлага үүсч, хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа мэдээллийн технологийн өөрчлөлт дотор өөрөө өөрчлөгдөж байгаагаа ч үл анзааран ажиллаж байснаа эргэн санахад бахархалтай байдаг.

Тэр үеийн компьютерийн хурд, хүчин чадал, хэрэгцээ шаардлагыг өнөөдөртэй харицуулахад үгээр хэлж, үйлээр харуулаад ч итгэмгүй өөрчлөлтүүд дэлхий дахинд, манай монгол улсад, манай татварын байгууллагад гарсныг дурдах хэрэгтэй юм.

Давуу талууд

- ☑ Сүүлийн 16 жилийн компьютерийн техникийн хөгжлийн үе шат бүрийг биеээр үзэж, нүдээр харан аливаа техникийн ашиглалтын явцад зайлшгүй гардаг техникийн эвдрэл, гэмтэл, доголдол, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор компьютерийн засвар үйлчилгээг хийж татварын албаны мэдээллийн техникийн хэвийн үйл ажиллагааг хангаж ирсэн манай компьютерийн инженерүүдийн авьяас чадвар, олон жилийн явцад хуримтлуулж ирсэн туршлага үнэлж баршгүй давуу тал юм.
- ☑ Эдгээр инженерүүдийн ажлын үр дүнд бид татварын албаны компьютерийн эвдрэл, гэмтэл, сүлжээ, мэдээллийн техникийн хэвийн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагын түвшинд авч ирсэн.
- ☑ Монголын татварын алба нь бусад төрийн байгууллагуудтай харицуулахад сүүлийн 10 гаруй жилд татварын хөгжлийн сан, шат шатны татварын албадын төсвийн орлогын үр дүнгийн гэрээний биелэлтийн давсан орлого, төсвийн хөрөнгө оруулалт, гадны байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, тусламж зэрэг хөрөнгийн эх үүсвэрээр Монголын татварын албыг компьютержүүлэх, техникжүүлэх боломж, нөхцөлүүд бүрдэж байсан.
- ☑ Монгол улсад тухайн үедээ л давуу гэж үзэж байсан компьютерийн сүлжээний технологийн дэвшилттэй хэлбэрүүдийг өөрийн байгууллагадаа нэвтрүүлэх, ашиглахыг манай мэдээлэл технологийн мэргэжилтнүүд аль ч үед анхааралын төвд байлгаж, хичээл зүтгэл гаргаж байсан нь өнөөгийн онцлог давуу байдал бий болгож байгаа юм.
- ☑ Хүчин чадал сайн мууч нийслэл, дүүргийн бараг бүх байцаагч компьютертэй болсон нь засвар, үйлчилгээний ажлын ачаалалыг нэмэгдүүлж нэгэн үе үйлчилгээний ажлаа дийлэхгүй болж байсан тул дүүргийн татварын албадад 2009 оноос компьютер инженерүүд авсан нь дээрх ажлын ачааллыг багасгахад мэдэгдэхүйц хувь нэмэр боллоо.

Дугагдалтай талууд

- ☒ Мэдээлэлийн систем нь цаг хугацааны альч үед хөрөнгө санхүүгийн хүндрэлтэй асуудалтай байнга тулгардаг бөгөөд тухайн шатны удирдлагуудын зөв ойлголт, зөв оновчтой шийдвэрээс цаашдын хөгжлийн хандлага ихээхэн хамааралтай явагддаг.
- ☒ Татварын албадуудад өөрсдийн хөрөнгө, санхүүгийн боломжинд тулгуурласан компьютер, түүний сэлбэг тоног төхөөрөмж авах, засвар үйлчилгээг хийхэд ТЕГ-аас стандарт нөхцөл шаардлага тавьж, бодлогоор зохицуулахын оронд хэт төвлөрүүлж, төвөөс бүх асуудлыг шийднэ гэсэн бодлого барьж байгаа нь хөрөнгө үргүй зарцуулах байдалд хүргэх нөгөө талаас ТЕГ-ын инженер техникийн ажилтнуудын ажлын ачааллыг ихэсгэх талтай юм.
- ☒ 1800 байцаагч 1800 компьютертэй байхад компьютерийн техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, програм хангамж, мэдээллийн баазын системийн найдвартай үйл ажиллагаа, сүлжээний ачаалал, нууцлалын асуудал, засвар үйлчилгээ, сэлбэг тоног төхөөрөмж зэрэг асуудлуудыг цаашид цогцоор нь яаж оновчтой шийдвэрлэх талаар нэгдсэн бодлого, стратеги төлөвлөгөө байхгүй байна

Цаашид тавих зорилгууд

- ☞ Татварын албаны мэдээллийн технологийн ойрын 3-4 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулж, мөрдөж ажиллуулах шаардлагтай байна.
- ☞ Татварын албад хоорондын онлайн холболтийн найдвартай ажиллагааг сайжруулж, татварын удирдлага болон сүлжээ түрээслэгч компаний удирдлагын түвшинд харилцан ярилцах, ойлголцох, итгэлцэх замаар түрээсийн зардыг бууруулах, дата дамжуулах хурдыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

- ☞ Монголын Татварын албаны төв сервер компьютерууд, төвлөрсөн мэдээллийн бааз, татварын албадууд дээрх мэдээллийн бааз, сүлжээний сервер компьютерүүд, тэдгээрийн найдвартай үйл ажиллагаа, мэдээллийн нууцлал, аюулгүй ажиллагааны байдал, мэдээллийн нөөц хадгалалт, сүлжээний тоног төхөөрөмжүүд, сүлжээний үйл ажиллагааны найдвартай байдал зэргийг байнга тогтвортой тасралтгүй хангах үйл ажиллагааг албаны хэмжээнд зохицуулсан бодлого, журам боловсруулж, мөрдүүлж, хэвшүүлэх шаардлагатай байна.
- ☞ Татварын байцаагчдийн өөрсдийн хариуцлагагүй үйл ажиллагаа, компьютерийн боловсролын өнөөгийн нийгмийн дундаж түвшний ойлголтгүйгээс компьютерээ гэмтээсэн, эвдсэн тохиолдрд байцаагчид хариуцлага тооцох, мөн байнгын хэрэглээний улмаас ердийн эвдрэл гарах магадлал өндөр байдаг маус, гар, принтерийн эвдрэл гэмтлийг нийтийн хэрэглээний засвар үйлчилгээгээр татварын албад өөрсдөө засуулж хэвийн ажиллагааг хангуулдаг болгох хэрэгтэй.
- ☞ Татварын албаны компьютерийн инженерүүд төвлөрсөн мэдээллийн баазын сервер компьютерүүд, сүлжээний тоног төхөөрөмж, сүлжээний үйл ажиллагааны найдвартай байдлыг хангах үүрэг хариуцлага дээр төвлөрч, ТЕГ-аас тогтоосон техник тоног төхөөрөмжийн стандартын шаардлагыг хангаж байгаад хяналт тавих, зохицуулах үүрэгтэйгээр ажиллах ёстой.
- ☞ Бусад төрийн болон хувийн байгууллагууд техник технологийн нарийн төвөгтэй асуудлуудыг яаж шийдвэрлэж байгаад судалгаа хийж, оновчтой шийдвэр, боломжтой хувилбарыг өөрийн байгууллагад нэвтрүүлэхэд цаг үргэлж бэлэн байх ёстой.

2.5 Мэдээллийн технологийн мэргэжилтэн, хүний нөөц

Өнөөгийн байдал

Мэдээллийн системийг үр ашигтай, үйл ажиллагааг тогтмол хэвийн явуулах хамгийн гол тулгуур хүчин зүйл нь програм хангамж, техникийн боловсролоор

мэрэгшсэн мэрэгжилтэн байдаг. Мэрэгжлийн боловсон хүчний мэдлэг боловсрол, хувь хүний төрөлхийн авьяас чадвар, ажлын туршлага, давтан сургах, мэрэгшүүлэх, тогтвор сууршилтай ажиллуулах удирдлагын менежмент, сэтгэл зүй, идэвхи санаачлагатай, бүтээлч ажиллах чадамж зэргээс ажлын үр дүн онцгой хамаардаг.

Өнөөдөр татварын албанд ажиллаж байгаа бүх програм хангамжийг боловсруулах болон компьютерийн техник тоног төхөөрмжийн засвар үйлчилгээг өөрсдийн мэргэжилтнүүдийн хүчээр хийж байгаа бөгөөд манай татварын албанд 9-16 жил ажилласан асар их ажлын туршлага хуримтлуулсан авьяас чадвартай 5 программ зохиогч, 3-компьютер инженер, 2-эдийн засагч ажиллаж байна. Эдгээр мэргэжилтнүүдийн хүч оюунаар өнөөдрийн татварын програмууд боловсруулагдаж, компьютер тоног төхөөрөмжүүд хэвийн үйл ажиллагаатай явагдаж байгаа юм.

Давуу талууд

- Програм зохиогч болон компьютерийн инженер нь өөрийн мэрэгжлийн хувьд өндөр чадвар, туршлагатай байхын зэрэгцээ байнгын хувьсан, хурдтай өөрчлөгдөж байгаа технологийн дэвшлийг мэдрэх, хурдан өөриймшүүлэх өөрчлөлтөд түргэн зохицож, хувьсаж, хэрэглэж чаддаг байх чадвартай байхыг өөрийн эрхгүй шаарддаг онцлогтой мэрэгжил юм.
- Нөгөө талаас мэрэгжлийн хувьд өндөр мэдлэг чадвартай ч тухайн байгууллагын мэрэгжлийн онцлог, мэдээллийн урсгалын талаар сайн ойлголтгүйгээр сайн програм боловсруулах боломжгүй байдаг. Өөрөөр хэлбэл татварын албаны мэдээллийн урсгалыг зохицуулах програм боловсруулахын тулд татварын мэргэжилтнүүдийн хэмжээнд татварыг мэдэх, зарим тохиолдолд тэднээс илүү өргөн хэмжээнд сэтгэж ойлгох шаардлага зайлшгүй гардаг. Энэ утгаараа манай одоогийн програм зохиогчид маань давхар мэрэгшсэн мэргэжилтнүүд учир хамгийн давуу нөхцөлийг бий болгож байна. Хамгийн сайн хэлтэй, боловсролтой програм зохиогчиор татварын програм бичүүлэхэд одоогийн програм зохиогчдын түвшинд хүрч татварын програм зохиоход хувь

хүнийхээ чадвар онцлогоос шалтгаалж доод тал нь 2-3 жил зарцуулна. Энэ нь бидэнд байгаа тэр тусмаа төрийн байгууллагад байгаа хамгийн давуу тал юм

Дугагдалтай талууд

- ☒ Төсвийн байгууллага нь цалин урамшуулал багатай тул өндөр мэрэгшсэн программ зохиогч, компьютер инженер шинээр ажилд сонгож авах, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг.
- ☒ Олон жил удаан ажиллаж мэрэгшсэн программ зохиогчийг өөр ажилд шилжүүлэх, ажлаас хөндийрүүлэхэд орлох мэрэгжилтэнг зүгшрүүлэхэд цаг хугацаа их шаардагдах болдог.
- ☒ Системийн хэмжээнд шаардлагатай бүх програм хангамжийг боловсруулахад одоогийн програм зохиогчдийн тоо цөөн байгаа бөгөөд нэмж орон тоо гаргахад цалингийн фондны асуудал шийдвэрлэхэд хүндрэл учирч байна. Иймээс программ зохиогчийн тоо цөөн, ачаалал харьцангуй их байгаа нь ажлын үр дүнд сөрөг нөлөөлж байна.

Цаашид тавих зорилгууд

- ☞ Давхар мэрэгшсэн программ зохиогч, компьютерийн инженерүүдийн давуу байдлыг тогтмол хадгалан үлдээх хэрэгтэй.
- ☞ Программ зохиогч болон техникийн инженерүүдийнхээ мэдлэг боловсролыг байнга дээшлүүлэх арга хэмжээг шат дараалан тогтмол авч байх ёстой.
- ☞ Ижил төстэй үүрэг хариуцлагатай төрийн болон хувийн байгууллагуудын мэрэгжилтнүүдтэй байнга харилцан туршлага солилцож байх хэрэгтэй.

- ☞ Гадаадын туршлагатай мэрэгжилтнүүдийг зохимжтой үед, шаардлагатай ажил дээр богино хугацаанд урилгаар авчран хамтран ажиллах, үр ашигтай арга хэмжээ зохиох хэрэгтэй.
- ☞ Программ зохиогч, техникийн инженерүүдийн хамтарсан техникийн зөвлөлийн хурлыг сар бүр тогтмол хуралдуулж хэвшүүлэх ёстой.
- ☞ Програмын засвар, өөрчлөлт, техникийн засварын захиалга авах, гүйцэтгэх нарийн хууваарьтай болгож мөрдөж хэвшүүлэх, үр дүнг тайлганадаг системтэй болох ёстой.

2.6 Татварын албаны нэг цэгийн үйлчилгээнд мэдээллийн технологи ашиглалт

2002 онд төвлөрсөн мэдээллийн бааз буюу ORACLE датабааз систем дээр татварын мэдээллийн баазыг үүсгэн, дотоод сүлжээнд онлайн горимд ажиллах програмуудыг боловсруулан татварын албадуудад нэвтрүүлж эхлэх үед үүссэн гол бэрхшээлүүд нь компьютерийн хүчин чадал, хүрэлцээ, тэдгээр дээр ажиллах татварын байцаагчийн чадвар зэрэг байлаа. Татварын бүх байцаагчийг шаардлага хангасан компьютерээр хангах боломжгүй, дээр нь байцаагчдийн нас, боловсролын түвшин, компьютер дээр ажиллах чадамж зэрэг нь харилцан адилгүй тул цөөн хэдэн шаардлага хангасан компьютерүүд дээр гол програмуудаа суулгаад компьютер дээр ажиллах чадвар арай гайгүй, хуруу гарны хөдөлгөөн сайтай байцаагчдыг ажиллуулах нь татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний чанар сайжирч, ажлын бүтээмж өндөртэй байх давуу талтай байв. Иймд эдгээр компьютерүүдийг нэг дор байрлуулан татварын хэрэглээний програмуудыг суулгаж, татвар төлөгчдөд тааламжтай сэтгэгдэл төрүүлэхээр ажлын байрны орчныг нь тохижуулан байрлуулснаар нэг цэгийн үйлчилгээний эхлэл тавигдсан юм.

Энэ үед зөвхөн манай татварын байгууллагад ч биш төвлөрсөн мэдээллийн бааз дээр суурилсан програм хангамж дээр ажиллаж хэрэглэгчид болон үйлчлүүлэгчиддээ цахим үйлчилгээ үзүүлэх шаардлагатай болсон банк, интернэт, үүрэн телефон, холбоо мэдээллийн компаниуд гэх мэт хувийн болон төрийн

байгууллагуудад дээрх шалтгаан, нөхцөл мөн л адил үүсч байсан тул манай улсад 2000 оны эхээс эхлэн одоог хүртэл “**нэг цэгийн үйлчилгээ**” нэртэй цахим үйлчилгээний газрууд эрчимтэй үүсэн хөгжиж цаг үетэйгээ хөл нийлүүлэн үйл ажиллагаа нь улам боловсронгуй болсоор байна.

Өнөөгийн байдал

Өнөөдрийн байдлаар татварын бүх албадад нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлсэн бөгөөд Нэг цэгийн үйлчилгээн дээрээ татвар төлөгчийг бүртгэх, татварын бүртгэл хийх, татварын тайлан хүлээн авах, татварын суутган тооцоолол хийх, татварын сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх зэрэг татвар төлөгчидтэй шууд харилцах үйлчилгээнүүдийг үзүүлж, энэ үйл ажиллагааны төрөл тус бүрээр боловсруулагдсан програмууд хэрэглэгчийн эрхээр хязгаартайгаар ажиллаж байгаа юм.

Ололттой талууд

- Нөөц бололцоондоо тулгуурлан техникийн шаардлага хангасан цөөн компьютер ашиглах боломжтой.
- Компьютер дээр ажиллах чадвар сайтай байцаагчдыг сонгон, тэднийг татварын бүртгэл болон тайлангийн програмууд дээр ажиллуулж, мэрэгшүүлснээр татвар төлөгчийн хүлээх цагийг хэмнэж, хүнд сурталыг багасгах хэрэгтэй.
- Татвар төлөгчдөд үйлчилгээний тааламжтай орчин бүрдүүлэх боломжтой.
- Татвар төлөгчдийг татварын албанд бүртгүүлэх, тайлан өгөх хүлээх явцад татварын сурталчилгаа, зөвлөгөө өгөх боломж, орчин бүрдэнэ.

Дутагдалтай талууд

- ☒ Нэг цэгийн үйлчилгээ нээх үед ажлын байрны тохижилт, компьютер, техник тоног төхөөрмжтэй холбоотой хөрөнгө, санхүүжилтийн асуудал нь төсвийн байгууллагуудад хүндрэл учруулах талтай.
- ☒ Татварын албадууд өөрийн байргүй буюу түрээсийн байранд байгаа тохиолдолд ажлын байрны тохижилт хийх, дахин нүүх зэрэгт давхар зардал гарах магадлалтай юм.
- ☒ Татварын хэрэглээний програмууд нь татвар төлөгчдөд хандсан нэг цэгийн үйлчилгээг төвлөрсөн зах, худалдааны цэгүүдэд нээж өргөтгөхөд техник, технологийн хүндрэл үүсгэж байна.

Цаашид тавих зорилт

- ☞ Нэг цэгийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа татвар төлөгчийн бүртгэл, татварын тайлангийн програмууд, татварын орлогын програмуудыг ойрын хугацаанд вэб хандалттай болгож өөрчлөх хэрэгтэй байна.
- ☞ Тайлан хүлээн авах үед татвар төлөгчийн бүртгэл, татварын бүртгэл, татвар төлөлт, татварын өр, тайлангийн ирцийн мэдээг харах бүрд харгалзах программ руу орж дахин татвар төлөгийн дугаарыг оруулж тухайн татвар төлөгчийн мэдээлэлийг харж байгаа дутагдалтай байдлыг өөрчлөх програмын өөрчлөлтийг хийх хэрэгтэй.

2.7 Татварын албаны цахим тайлан

Одоогийн нөхцөл байдал

Монгол улсад 2004 оноос эхлэн холбоо мэдээллийн дэд бүтэц сайжирч хэрэглэгчид интернэтэд орох боломжууд нэмэгдэж, зардал, үнэ буурч эхэлсэн нь байгууллага, иргэд интернэт ашиглан өөрсдийн WEB хуудас үүсгэн түүгээрээ

дамжуулан зардал багатай, хугацаа хэмнэсэн үйлчилгээ үзүүлэх өргөн боломжууд бүрдэж эхэлсэн билээ.

Интернэтийн браузерээр дэмжигдсэн программ хангамж нь хэрэглэгч өөрийн компьютер дээр програмыг суулгахгүйгээр програмын тухайн хэрэглэгчид шаардлагатай зарим модулиудыг ашиглах хязгаарлагдмал эрх авснаар интернэтэд орж шууд уг программыг ашиглах боломжтой болдог гайхамшигт онцлогоороо цахим ертөнцөд хэмжээлшгүй их давуу байдлыг бий болгосон юм. Энэ давуу талаараа өнөөдөр вэб хандалттай програм хангамж дэлхийн мэдээллийн технологид хөгжлийн үсрэлт авчирч байгаа юм.

Татварын алба нь өөрийн мэргэшсэн, чадварлаг мэргэжилтнүүдийн хүчээр 2006 оноос татварын цахим тайлангийн программуудыг боловсруулж, нэвтрүүлж эхлээд байгаа бөгөөд ямарч програмыг хэрэглэгчид ашиглаж сурах, програмыг турших, зүгшрүүлэх явцад гардаг байнгын болон ердийн хүндрэл бэрхшээлүүд алхам бүрдээ учирсаар байгаа бөгөөд цаашид улам боловсронгуй болгон хөгжүүлэх эхлэлийн шатандаа явж байна.

Өнөөдрийн байдлаар НӨАТ, ААНОАТ, ХХОАТ-ын цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын тайланг цахим хэлбэрээр интернэтээр авч, НӨАТ-ын падаан шивэх програмыг Татварын албаны WEB сайтаас хэрэглэгч өөрийн компьютер дээр татаж суулган, уг программаар шивж оруулсан НӨАТ-ын падааны мэдээг сар бүр татварын албанд интернэтээр дамжуулан хүргүүлэх боломжтойгоор боловсруулан нэвтрүүлээд байгаа юм.

Ололттой талууд

- Татварын цахим тайлангийн программууд нь татвар төлөгчид цаг хугацаа болон зардал хэмнэх, интернэтэд орох боломжтой компьютерд хаана байгаагаас үл хамааран үйлчилгээ авах боломж бүрдүүлж байгаа юм.

- ☒ Татвар төлөгч татварын тайланг хуульд заасан хугацаанд татварын албаны ажлын өдөр, цагт баригдахгүйгээр долоо хоногийн(Бямба, Нямд ч ажиллана) 24 цагийн аль ч үед илгээх боломжтой

Дугагдалтай талууд

- ☒ Татвар төлөгч нь интернэтэд холбогдсон компьютертэй байх, интернэт ашиглах энгийн мэдлэг чадвартай болсон байх шаардлага заавал тавигдана.
- ☒ Улс орны холбоо мэдээллийн дэд бүтэц болон тухайн байгууллага, иргэний интернэтэд орох хурд нөгөө талаас манай татварын албаны интернэт орох хөрөнгө, санхүүд хязгаарлагдсан хэрэглээний хурдаас хамаарч ачаалал үүсэх, цахим тайлангийн системд нэвтэрхэд дараалал үүсгэх, татвар төлөгчийг хүлээлгэж бухимдал үүсгэх магадлалтай .
- ☒ Татвар төлөгчийн компьютерийн хэрэглээний мэдлэг, чадамжаас шалтгаалж цахим тайланд техникийн алдаа гарах магадлал маш өндөр байгаа нь татварын албанд хүндрэл учруулж байна.
- ☒ Татвар төлөгч хуулийн хугацаанд тайлангаа өгөөгүй хоцроосны торгууль, шийтгэлээс зайлсхийж хуурамч тайлан өгөх, дараа нь залруулах гэх мэт татварын албаны ажлыг хүндрүүлсэн хууран мэхлэх үйл ажиллагаа явуулах магадлал өндөр байна.
- ☒ Интернэтээр татвар төлөгчийн мэдээлэл алдагдах, халдлагад өртөх магадлал өндөр тул нууцлал, аюулгүй ажиллагаан дээр өндөр анхаарал хандуулах, маш нарийн нууцлалын түвшин өндөртэй програм хангамжийг өндөр үнээр худалдаж авах шаардлага үүсч болно.
- ☒ “Тоон гарын үсэг” бүхий хувийн болон нийтийн түлхүүрийн хууль, эрх зүйн акт бүрдээгүй байгаа учир татварын цахим тайлангууд нь татварын болон санхүү бүртгэлд санхүүгийн баталгаажсан баримт бичиг биш болох тул татвар төлөгч

заавал татварын албанд тайланг баталгаажсан эх хувиар нь цаасаар авчирч өгөх шаардлагатай.

Цаашид тавих зорилтууд

- ☞ Интернэтээр үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэвтрүүлэх үед тухайн байгууллагад улс орны дэд бүтцийн хөгжил, хөрөнгө мөнгөний чадамжтай холбогдон гарч ирэх өргөн зурвасаар ашиглах интернэт оролтын хурд, хэрэглэгчийн хэрэгцээний шаардлага, хэрэглэх чадамж, компьютерийн хүчин чадал нөгөө талаас нь програм зохиогч болон техникийн мэргэжилтнүүдийн өндөр мэргэшсэн ур чадвар, тогтвор сууршилтай үйл ажиллагаа, уйгагүй, тасралтгүй, тууштай явуулах удирдлагын менежмент зэрэг олон зүйлээс шалтгаалсан том жижиг хүндрэлтэй асуудлууд үүсдэгийг анхаарах хэрэгтэй юм.
- ☞ Интернэт ашиглаж татварын цахим тайлан илгээх татвар төлөгчдэд энгийн ойлгогдох сургалт, сурталчилгааг хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр байнгын, тасралтгүй явуулж хэвшүүлэх шаардлагатай.
- ☞ Цахим тайлангийн програмуудад тайлан оруулах, хадгалах, илгээх, дамжуулах тайлангийн маягтыг бөглөх дараалалыг маш тодорхой алхам бүрээр нь нарийвчлан заасан тусламжийн файлыг программ идэвхтэй үед татвар төлөгч дэлгэцнээс шууд, хурдан хялбар харж болохоор байршуулах хэрэгтэй.
- ☞ Татвар төлөгч татварын цахим тайлан бөглөх үед гаргаж болох техникийн алдаануудаас зайлах бүх нөхцлийг програмд тусгаж өгөхийн зэрэгцээ, тайлан шивэх үед техникийн алдаа гаргахаас болгоомжлуулсан, тоон үзүүлэлт оруулж байхад татварын тайлангууд мянгачилж оруулдаг болохыг байнга сануулсан сануулгыг тайлангийн цахим хуудсанд хулганы заагчийн байрлалд байршуулах хэрэгтэй.

2.8 Татварын албаны WEB хуудас

Өнөөгийн нөхцөл байдал

WWW үүсэн хөгжсөн цагаас эхлэн тогтсон нэг ойлголт бол вэб хуудас нь аливаа байгууллагын хувьд өөрийн нүүр царайг зах хязгааргүй интернет орчинд олон нийтэд хүртээх гарц болохын зэрэгцээ маркетинг зар сурталчилгааны хямд төсөр, үр дүнтэй хэрэгсэл болсоор ирсэн билээ. Вэб хуудас нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран байнга нээлттэй байж сурталчилгааны зардлыг багасгах онцгой давуу талтай юм.

Монголын татварын алба 2003 онд програм зохиогчдын санаачлагаар Татварын вэб хуудсыг анх үүсгэн ажиллуулж эхэлсэн боловч удирдлага, менежментийн зүгээс төдийлөн анхаарал тавиагүй, вэб бүтээгчийн хувьд тухайн үед туршлага дутмаг, монгол улсад интернэт хэрэглээ өнөөдөртэй харицуулахад харьцангуй сул байсан зэргээс шалтгаалж үндсэндээ зогсонги байдалтай явсаар 2006 оны сүүлтэй золгосон билээ. 2007 оны эхээр USAID хөтөлбөртэй хамтран дахин вэб хуудасны дизайныг өөрчлөн зохион байгуулсан боловч хариуцсан тогтвортой вэбмастер байхгүй, програм зохиогчид хавсрага шинжтэй авч явдаг, вэб сайтыг байнга хөгжүүлж, шинэчилж авч явах байгууллагын нэгдсэн бодлого байхгүй зэргээс өнөөгийн шаардлагаас нилээд хоцрогдонгүй явж байна.

Ололт, дэвшилттэй талууд

- Тухайн байгууллага нь өөрийн вэб хуудсандаа оновчтой нэр өгөх нь цаашид түүгээр дамжуулан үйлчлүүлэгчиддээ үзүүлэх үйл ажиллагаанд онцгой ач холбогдолтой байдаг. Монголын Татварын албаны вэб хуудас www.mta.mn гэсэн нэртэй гэдгийг татвар төлөгчид таньж мэддэг болсон.
- Татварын тухай хууль, журам, дүрэм, заавар, мэдээлэл зэрэг нь аливаа улсын ард иргэдийн эрэлт хэрэгцээ ихтэй, шаардлагатай мэдээллийн нэг зайлшгүй мөн тул энэ мэдээллийг ард иргэдэд төрийн зүгээс түгээх, хүргэх үүрэг

хариуцлага бүхий татварын байгууллагын вэб хуудсанд нэвтэрч хэрэгцээт мэдээлэлээ авах нийгмийн шаардлага өндөр байгааг манай вэб хуудасыг хэрэглэгчийн тооны өнгөрсөн хугацааны статистик дүн харуулсан.

- ☑ Байгууллагын вэб хуудасны хэрэгцээ ач холбогдлыг удирдлага, системийн хэмжээний бүх ажилтанууд ойлгон ухамсарлаж цаашид боловсронгуй болгох, сайжруулах, төгөлдөршүүлэх талаар санаа тавьж санал, шүүмжлэл өрнүүлж эхэлсэн нь маш том ололт дэвшилттэй тал юм.

Дугагдалтай талууд

- ☑ Байгууллагын вэб хуудасны дизайн загварыг боловсруулж, шинэчилж өөрчилж байх тогтмол сууршилтай ажиллах вэбмастер байхгүй байна.
- ☑ Байгууллагын зүгээс байгууллагын вэбсайтын мэдээлэлийг хэзээ, хаана, ямар хугацаанд, хэн, яаж өөрчилж байхыг тусгасан дүрэм журам байхгүйгээс мэдээллийн шинэчилэлт цаг хугацаандаа хийгдэхгүй, хоцрогдсон, “*үхмэл*” хэлбэртэй байна.

Цаашид тавих зорилгууд

Байнгын-Амьд-Хиртээмжтэй-Гр өгсөжтэй-Таашаалтай-Хэрэгцээтэй вэб сайт байхын тулд:

- ☞ Байгууллагын вэб сайтын загвар дизайн, бүтэц зохион байгуулалтыг дахин өөрчилж олон талаас нь хэлэлцэн татварын албаны вэбсайтад нэвтэрсэн татвар төлөгч хэрэгцээт мэдээллээ олж авахад ойлгомжтой, энгийн, хүртээмжтэй, үр ашигтай, сонирхол татахуйц байхаар нүүр хуудсыг өөрчилж, холбоос хуудсуудын мэдээллийн агуулгыг сайжруулж нэг хэвийн загварт оруулж цаашид байнга тогтвортой байлгах

- ☞ Вэбсайтын загвар, дизайн мэдээллийн агуулга тогтмол болж ирэх үед гадаад хэл дээр орчуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх
- ☞ Байгууллагын вэбсайтын мэдээлэл өөрчлөх үйл ажиллагааг зохицуулсан журам боловсруулж даргын тушаалаар батлуулж, цаашид тогтмол мөрдүүлж хэвших
- ☞ Байгууллагын зорилт, зорилго, үйл ажиллагааг сурталчилсан хөдөлгөөнт баннер, найдвартай тэргүүний татвар төлөгчдийн үйл ажиллагааг сурталчилсан, жилийн турш байрлуулах хүндэтгэлийн булан баннер, татвар төлөгчдөд зориулсан цаг хугацааны шаардлагатай мэдээ, мэдээллэл, сурталчилагаа харуулсан хөдөлгөөнт баннер зэргийг байрлуулах
- ☞ Зайн сургалтанд орчин үеийн дэвшилтэд технологийн дагуу видео хичээл оруулж, татварын тэргүүний туршлагатай багш нарын видео хичээл байршуулах
- ☞ Татварын асуулт хариултыг байнга шинэчилж, татвар төлөгч татварын асуултын хариултыг чихэвчээр дуут хэлбэрээр сонсож болох сонирхолтой булан байршуулах
- ☞ Татварын хууль тогтоомж, үйл ажиллагааны талаар янз бүрийн олон нийтийг хамруулсан тодорхой хугацааны хэлэлцүүлэг явуулж дүгнэлт, судалгаа гаргах боломжтой хуудас хийж байршуулах хэрэгтэй.
- ☞ Байгууллагын вэбсайтыг зөвхөн програм, дизайн, технологи тал руу нь анхаараад байгууллагын маркетинг, хэвлэл мэдээлэл, зар сурталчилгаа зэрэг бизнес үйл ажиллагааны менежментийн тасралтгүй үйл ажиллаганы бодлого талыг орхигдуулаад байдгийг анхаарах ёстой.
- ☞ Вэбсайтын эрэмбэ дараалал сайтай байршуулсан мэдээлэл нь олон жилийн дараа “**байгууллагын цахим архивын мэдээ**” болох боломжтойг анхаарч хуудас бүр дээр он дарааллын хадгалалтын асуудлийг анхаарч алсын хараатай, зөв зохион байгуулалттай хадгалах асуудлыг анхаарах

3. ТАТАВАРЫН АЛБАНЫЙ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖИНГҮЙ ОРНЫ ТҮВШИНД ХҮРГЭХ ГАДААД БОЛОН ДОТООД ТААЛАМЖТАЙ НӨХЦӨЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮҮЛЭХ БОЛОМЖ

Гадаад тааламжтай нөхцөл

- Даяаршлагдан байгаа дэлхий нийтийн хөгжил, шинжлэх ухаан мэдээллийн ололт дэвшилийн үр дүнд мэдээлэл холбооны технологи, компьютерийн техникийн хурд, багтаамж, хүчин чадал хэдэн арав дахин нэмэгдсэн, үнэ өртөг харьцангуй буурах хандлагатай болсон.
- Монгол улсад холбоо мэдээллийн дэд бүтэц 2004-2010 онд харицангуй сайжирч, интернэт хэрэглэгчийн тоо нэмэгдэж, үнэ багасан, интернэт оролтын хурд ихэссэн зэрэг эерэг үзүүлэлтүүд гарч эхлээд байна.
- Улсын хэмжээний шилэн кабельд суурилсан сүлжээний дэд бүтэц бий болж, шилэн кабелийн дэд бүтэцээс салаалсан байгууллагын салбар хоорондын сүлжээг шилэн кабелийн шөрмөс ашиглан хийх тааламжтай нөхцөл бүрдсэн. Шилэн кабелийн холболтын болон түрээсийн үнэ харицангуй буурч байна.
- Интернэт браузерар дэмжигдсэн вэб хандалттай програмын хэлний технологиуд илүү дэвшилттэй, ашиглахад хялбар дөхөм боловсронгуй болж байна.
- Монгол улсын нийт ард иргэдийн компьютер хэрэглээний боловсрол, интернэт хэрэглээний түвшин сүүлийн жилүүдэд харьцангуй хурдтай өсөж байгаа зэрэг гадаад эерэг тааламжтай нөхцөлүүд бүрдээд байгаа юм

Дотоод тааламжтай нөхцөл

- ☑ Хэдийгээр татварын мэдээллийн системд програм хангамж, техник технологийн хувьд цаашид сайжруулах, төгөлдөршүүлэх зүйл олон байгаа ч гэсэн татварын албаны төвлөрсөн мэдээллийн бааз үүсэж тодорхой хугацааны(сүүлийн 10 жил) мэдээлэл хуримтлагдсан байгаа нь цаашид энэ мэдээлэл дээр тулгуурлан татварын албаны мэдээллийн технологийн одоогийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, статистик судалгаа хийх боломж бүрдсэн байгаа юм.

- ☑ Татварын мэдээллийн технологийн мэрэгжилтэн, програм зохиогч, инженерүүд нь олон жилийн дадлага туршлагатай, татварын мэрэгжлээр давхар мэрэгшсэн байгаа нь үнэ цэнэтэй давуу тал болж байна.

- ☑ Татварын бүх албадыг шилэн кабелиар онлайн холбож дууссан, цаашид тогтвортой ажиллуулах, түрээсийн зардлыг бууруулах тааламжтай боломж байгаа.

- ☑ Дэлхийн банкны буцалтгүй тусламжийн хүрээнд татварын хэрэглээний програмуудыг вэб хандалттай програм болгож өөрчлөх, хөгжүүлэх боломж бүрдэж байгаа зэрэг нь өнөөгийн татварын албаны мэдээлэл технологийн хөгжлийг ойрын 2-3 жилийн хугацаанд хөгжингүй орны түвшинд хүргэх боломж бүрдүүлж байгаа юм.

Г.Батсайхан

ТЕГ, Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн дарга

Математикийн ухааны магистр

oooOooo